

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/20.

Арвайхээр

Хөрөнгийн тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээ явуулах тухай” 241 дүгээр тогтоол, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөрөнгийн тооллого зохион байгуулах бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор хөрөнгийг нэг бүрчилсэн байдлаар эд хариуцагч нарын хөрөнгө эзэмшигчийн карттай тулган баталгаажуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхөж ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг актлах, данснаас хасах, шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэж Аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлж тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа)-д даалгасугай.


3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Хөрөнгийн тооллогын комисс томилох тухай” тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 06 дугаар сарын 09-ны
өдрийн 420-р тушаалын хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ХӨРӨНГИЙН ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын ахлагч:

Н.Төгс-Очир - Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

М.Мөнхбаатар - Эдийн засагч

Б.Долзодмаа - Халдварт өвчин, дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан

Н.Дэжидням – Эмийн чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн

Ч.Ган-Очир - Жижүүр